**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БОЛОН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХООРОНД ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО**

/2021 оны жилийн эцсийн байдлаар/

| | |
|---|---|
| нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх гэрээнд хамтран хэрэгжүүлэхээр туссан нийт 30 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлт 98,6%-тай байна. | |
| Хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан Нийт-30 арга хэмжээ | |
| Бүрэн хэрэгжсэн /100%/ | 28 |
| Хэрэгжих шатанд /70%/ | 2 |
| Хэрэгжилт хангалтгүй /30%/ | - |
| Хэрэгжээгүй / 0% / | - |
| Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй | - |
| **Биелэлтийн үнэлгээний хувь** | 98% |

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.САНЖИЙЖАМЦ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ЭРХ ЗҮЙ, ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ,
ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН С.ЦЭНД-АЮУШ

НЭГТГЭСЭН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Х.ЦЭЦЭГСҮРЭН

# НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БОЛОН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХООРОНД ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

/ 2021 оны жилийн эцсийн байдлаар /

2021.12.30

Багахангай дүүрэг

| № | Холбогдох заалт | Биелэлт | Хэрэгжилтийн хувь | Үнэлгээ |
|---|---|---|---|---|
| **Гурав. Төлөөлөн хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг** | | | | |
| 3.1 | Төсвийн тухай хуулийн 61.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор арга зүй, зохион байгуулалтын шуурхай удирдлагаар хангах, зохицуулах үйл ажиллагааг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд эрхлэн гүйцэтгэж, уг гэрээнд тусгагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэн, түүний үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцна. | Дүүргийн хэмжээнд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжиж байгаа 3 байгууллага байна. Үүнд:<br>➢ Хангай цогцолбор сургууль<br>➢ 44-р цэцэрлэг<br>➢ 207-р цэцэрлэг<br>Тус байгууллагуудыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулалтыг чанар үр дүнтэй удирдлагаар байнга хангаж, төсвийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд хяналт тавих, хөтөлбөрийн хэрэгжилт, үйлчилгээний стандарт тоо хэмжээ, чанар, хүртээмжийг сайжруулахад анхаарч ажилласнаар нийгмийн хөгжлийн хүрээнд хэрэгжүүлж буй хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд дэвшүүлсэн зорилтын хүрэх түвшнээс дээгүүр үзүүлэлттэй байна. | 100 | 100% |
| 3.2 | "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (суурь түвшин, шалгуур үзүүлэлт, шаардагдах хөрөнгө, хугацаа, хүрэх түвшин) бүрээр хангаж хэрэгжүүлнэ. | Нийслэл, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Засаг даргын Тамгын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилт, 138 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа. 2021 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлт 94,2 хувийн биелэлттэй хэрэгжлээ. 2021 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлт 6 зорилтын 138 хэрэгжүүлэх арга хэмжээнээс 100% | 90 | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | бүрэн биелэсэн 103, хэрэгжих шатанд 70%-тай 20, хэрэгжилт хангалтгүй 30%-тай 2, тасарсен 1 заалт буюу 94,8 хувийн биелэлттэй хэрэгжлээ. | | |
| 3.3 | Засгийн газрын зарим чиг үүргийг хэрэгжүүлэгч орон нутгийн байгууллагуудын удирдах албан тушаалтныг томилох, чөлөөлөх, халах болон эрх бүхий байгууллагатай зөвшилцөхдөө Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөнө. | 2021 онд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.2 дахь заалтын дагуу "Багахангай-Тохижилт" ОНӨААТҮГ-ын захирлын албан үүргийг Ч.Батхуягт хавсруулан гүйцэтгүүлэв.<br>Мөн Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт заасны дагуу Х.Цогцэцэгийг Засаг даргын зөвлөхөөр томилсон бөгөөд, 2021 оны 10 дугаар сарын 11-ний Б/15-р захирамжаар үүрэгт ажлаас чөлөөлсөн байна.<br>Тэтгэвэрт гарах насанд хүрч ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан Хангай цогцолбор сургуулийн захирал С.Баатархүүг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас чөлөөлөв.<br>Сонгуулийн бүрэн эрхийн хугацаа дууссан 1 дүгээр хорооны Засаг дарга Б.Гэрэлмаа, 2 дугаар хорооны Засаг дарга М.Өсөхдэлгэр нарыг 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас чөлөөлж, хороодын Иргэдийн Нийтийн хурлаас иргэдийн олонхийн санал авсан Н.Нямзавыг 1 дүгээр хорооны Засаг даргаар, Б.Батзоригийг 2 дугаар хорооны Засаг даргаар тус тус томилов.<br>Тайлангийн хугацаанд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу ажлаас халагдсан албан тушаалтан байхгүй байна. | 100 | 100% |
| 3.4 | Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх бодлого боловсруулах, шийдвэр гаргах бүртээ үндэсний язгуур ашиг сонирхлыг эрхэмлэж, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хууль, тогтоомжийн холбогдох заалттай уялдуулж байх | Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх бодлого боловсруулах, шийдвэр гаргах тухай бүр үндэсний язгуур ашиг сонирхлыг эрхэмлэж, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэл, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлтэй уялдуулан боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллав. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн эхний хагас жилийн биелэлт 70%-ийн гүйцэтгэлтэй байна. | 90 | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Нийслэлийн Засаг дарга бөгөөд улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн жилийн эцсийн биелэлт 87.7%-тай, 2021 оны төлөвлөгөөний биелэлт 90.4%-тай тус тус хэрэгжив. дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2021 оны төлөвлөгөөний биелэлт 92%-тай хэрэгжсэн байна. "Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2021 оны жилийн эцсийн байдлаар 80%-тай хэрэгжив. | | |
| 3.5 | Энэхүү гэрээний 3.3-т заасан байгууллагын бүтэц, зохион байгуулалт, бодлогын асуудлаар шийдвэр гаргахдаа Нийслэлийн Засаг даргатай зөвшилцөнө. | Засгийн газрын 2019 оны 100 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2020 оны А/121 дүгээр захирамжаар тус ЗДТГ-ын бүтэц, орон тоог 25 байхаар тогтоосны дагуу дүүргийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/44 дүгээр захирамжаар бүтэц, орон тоог шинэчлэн баталсан бөгөөд бүтэц, орон тооноос илүү томилсон албан хаагч байхгүй байна.<br>Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 03 дугаар тогтоолоор батлагдсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах журам"-д нийцүүлэн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт боловсруулах, ажлын байрны шинжилгээ хийх ажлын хэсгийг байгуулан чиг үүргийн давхардал хийдлийг арилгах зорилгоор ажлын байрны шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолтуудыг шинэчлэн боловсруулж, Төрийн албаны зөвлөлөөр хянуулан Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 266 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | 100 | 100% |
| 3.6 | Засгийн газрын зарим чиг үүргийг өөрийн нутаг дэвсгэрт төлөөлөн хэрэгжүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 39.4-т заасан шаардлагыг хангаж ажиллана. | Тусгай зориулалтын шилжүүлгийг орон нутгийн суурь зарлага болон бусад зардлын санхүүжилтэд шилжүүлээгүй болно. | 100 | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3.7 | Засгийн газрын зарим чиг үүргийг хэрэгжүүлэгч орон нутгийн байгууллагуудын төсвийн шууд захирагч нартай хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үр дүнгийн гэрээг байгуулах бөгөөд үр дүнгийн гэрээ нь энэхүү гэрээг үндэслэсэн байна. | Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй 22 аж ахуйн нэгж, байгууллагад Засгийн газрын хэрэг эрхлэх газрын "Аргачлал, загвар батлах тухай" 100 дугаар тушаалыг хүргүүлэн, гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан боловсруулах талаар заавар, зөвлөгөөг өгч, 22 байгууллагын төлөвлөгөөг дүүргийн Засаг даргаар батлуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Байгууллагуудын 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн дотор ирүүлэх тухай албан бичгийг холбогдох аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсний дагуу дүүргийн 22 харьяа байгууллага 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан ирүүлснийг үнэлж, 22 байгууллага бүрэн хангалттай үнэлгээ авсан байна. Үнэлгээний дүнг үндэслэн дүүргийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Б/28 дугаар захирамжаар сарын үндсэн цалингийн 40 хувиар урамшуулал олгохоор шийдвэрлэсэн байна.<br>ЗДТГ-ын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад арга зүйн заавар зөвлөмжийг өгч ажиллав. Журамд заасны дагуу нэгжийн менежер-4, төрийн захиргааны 20, төрийн тусгай 3, төрийн үйлчилгээний-15, гэрээт-8 албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөө, 5 албан хаагч үр дүнгийн гэрээг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллав. Албан хаагчдын 2021 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайланг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор авч дүгнэв. Байгууллагын үнэлгээний багийг даргын тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, 2021 оны 12 дугаар сарын 10-ны дотор гүйцэтгэлийн тайланг авч, 51 албан хаагчийн гүйцэтгэлийг үнэлэн ЗДТГ-ын даргын тушаалаар сарын үндсэн цалингийн 36-40 хувьтай тэнцэх хэмжээний урамшуулал олголоо. Байгууллагын үнэлгээний багийг ЗДТГ-ын даргын тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулав. | 90 | 100% |
| 3.8 | Дүүргийн Засаг дарга нь энэхүү гэрээний 7 дугаар зүйлийн 7.1, 7.2-д заасан тайлант хугацаанд хэрэгжилтийн тайланг ирүүлнэ. | Энэхүү гэрээний 7 дугаар зүйлийн 7.1, 7.2-д заасан тайлан биелэлтийг цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна. | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3.9 | Дүүргийн төсвийн байгууллага болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын төсвийн орлого, зарлага, тайлангийн бүх мэдээллийг олон нийтэд ил тод байхаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллана. | Төсөв санхүүгийн тайлан, мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн, www.bagakhangai.ub.gov.mn сайт, шилэн дансны www.shilendans.gov.mn сайтад тогтмол байршуулж хэвшлээ. Үүнд:<br>□ 2021 оны төсөв баталсан Дүүргийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 14 өдрийн А/09 тоот тогтоол<br>□ 2021 оны төсөв баталсан Дүүргийн ИТХ-ын 2021 оны “Төсөвт өөрчлөлт оруулах” тухай 2021 оны 10 дүгээр сарын 21-ны А/03 тоот тогтоол<br>□ Дүүргийн төсвийн орлогын 1-11 дүгээр сарын мэдээ<br>□ 2022 оны төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөлөл<br>□ Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан<br>□ Дүүргийн төсвийн сар бүрийн гүйцэтгэлийн нэгтгэсэн мэдээ /1-11/<br>□ 2020 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар “Зөрчилгүй” санал дүгнэлттэй шалгагдсан бөгөөд тус Аудитын дүгнэлтийг хуулинд заасан хугацаанд тус тус байршуулсан.<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг иргэд, олон нийтийн хяналт дор, ил тод өрсөлдөх тэгш боломжийг хангах үүднээс хуулийн хүрээнд үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулж, гүйцэтгэлийн явцын мэдээг тухай бүр Сангийн яамны www.mof.gov.mn сайт, Засгийн газрын www.tender.mn, дүүргийн www.bagakhangai.ub.gov.mn сайтуудад тус тус байршуулан ажилласан байна.<br>Сангийн яамны www.mof.gov.mn сайтад ОНХС-ийн 2021 оны төлөвлөгөө, хэрэгжсэн ажлуудын гүйцэтгэл болон холбогдох мэдээ мэдээллийг тухай бүр шивж оруулан, баяжуулан ажиллав.<br>1. Дүүргийн www.bagakhangai.ub.gov.mn сайтад:<br>1.1. 2021 оны худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөг 2021.01.10-ны өдөр,<br>1.2. “Худалдан авах ажиллагааны 2021 оны бараа, | 90 | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | ажил, үйлчилгээ худалдан авалтын ерөнхий тайлан" 2021.03.31-ний өдөр,<br>1.3. "2020 оны Орон нутгийн хөгжлийн санд хийсэн санхүүгийн аудитын тайлан"-г 2021.04.15-ны өдөр,<br>1.4. Гар утасны апликэйшнээр 2022 оны ОНХС-ын саналыг 2021.03.01- нээс 2021.04.20-ны өдөр авч бүрэн дууссан, мэдээллийг LDF.gov.m, Open.ulaanbaatar.mn сайтуудад байршуулсан.<br>1.5. Хөрөнгө оруулалтын барьцаа дансны 2020 оны жилийн эцсийн мэдээ 2021.01.10-ны өдөр,<br>Тус онд тендерийн 14 урилгыг дүүргийн www.bagakhangai.ub.gov.mn, Засгийн газрын www.tender.gov.mn сайтуудад тухай бүр нь байршуулан, иргэдэд ил тод ажлаа тайлагнан ажиллалаа. | | |
| 3.10 | Эрүүл ахуйн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, тогтоомж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 63, 2012 оны 61 дүгээр тогтоолын хэрэгжилтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах, орчны тохижилт, цэвэрлэгээний шаардлагыг хангуулах замаар хотын өнгө үзэмжийг сайжруулахад хувь нэмэр оруулах, гадна талбайн угаалга, цэвэрлэгээ, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг хариуцан зохион байгуулна. | ААНБ-ын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор орон сууцны айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудын цас мөс цэвэрлэх, хог хаягдлыг авах зураглал болон цагийн хуваарийг дүүргийн Засаг даргын орлогч, хороодын засаг даргаар баталгаажуулан гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад мөрдүүлэн ажиллаж байна.<br>Дүүргийн хэмжээнд хог цуглуулалт тээвэрлэлт тогтоогдсон график, цагийн хуваарийн дагуу хугацаандаа тогтмол явагдаж байна. Хороод, "Тохижилт, цэвэрлэгээний гурвалсан гэрээ", Багахангай тохижилт" ОНӨААТҮГ "Хог ачиж тээвэрлэх гэрээ"-г дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй 71 ААНБ-тай байгуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>Дүүргийн Багахангай тохижилт ОНӨААТҮГ нь Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон дүүргийн Засаг даргатай "Хог ачиж, тээвэрлэх гэрээ" байгуулан гэрээний хэрэгжилтийг ханган сар бүрийн 25-ны дотор дүгнүүлэн ажиллав.<br>Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хийсэн 21/07-44 дугаартай гэрээний дагуу 2021 оны 03 дугаар сарын 15-наас 12 дугаар сарын 15 хүртэлх хугацаанд дүүргийн хороодын 4 иргэнийг түр ажлын байраар ханган ажилласан байна<br>2 иргэдийн бүлгийн 4 иргэний гүйцэтгэлд хяналт тавьж, 10 | 100 | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | удаа дүгнэн УБЗАА-нд хүргүүлэн санхүүжилтийг дүүргийн СТСХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ 4 иргэнд 9.2 сая төгрөгийн урамшуулал олгов.<br>Тайлангийн хугацаанд "Бүх нийтийн их цэвэрлэгээ"-г 4, Цас цэвэрлэгээ 1 удаа, "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ түүвэр цэвэрлэгээг 8 удаа зохион байгуулав.<br>Бүх нийтийн цэвэрлэгээнд: давхардсан тоогоор 121 ААНБ, иргэн 877 албан хаагч оролцож 146109 $м^2$ талбайн үүсмэл хог хаягдлыг цэвэрлэж 39,5тн хогийг төвлөрсөн хогийн цэгт буулгав.<br>Цас цэвэрлэгээнд:Нийт 24 аж ахуйн нэгж, байгууллагын 283 ажилтан, албан хаагчид оролцов.<br>Түүвэр цэвэрлэгээ 65.350$м^2$ талбайн 21тн хог хаягдлыг татан авч дарж булшилсан.<br>Шарилжгүй Улаанбаатар 6" аяны удирдамжийн дагуу зэрлэг ургамал устгах ажлыг 2 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 127 аж ахуйн нэгж, байгууллагын 595 ажилтан, албан хаагч, 95 өрхийн иргэн **156916**$м^2$ талбайн шарилжийг цэвэрлэв.<br>Дүүргийн "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ хороо тус бүрт 1 хог тээврийн машин ажиллаж, цэвэрлэсэн **18.5тн** ургамлыг дүүргийн мал бүхий иргэдэд малын тэжээл бэлтгэхэд нь зориулан өгсөн байна<br>Уг ажилд ТХҮҮХ болон хороодын тохижилт, хог хаягдлын олон нийтийн байцаагч нар хяналт тавьж ажилласан байна.<br>Хог хаягдлын орлогын төлөвлөгөө 20.000.000 төгрөг төвлөрүүлэхээс 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 17.355.784 төгрөг төвлөрч 87%-н гүйцэтгэлтэй байна.<br>2015 оноос үүргийн Засаг даргын захирамжаар хороодод тохижилт, хог хаягдлын олон нийтийн байцаагчийг томилон, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн орчны бохирдол, хог хаягдал, цэвэрлэгээ үйлчилгээнд хяналт тавин | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | ажиллаж байгаа бөгөөд эхний хагас жилийн байдлаар 56 зөрчлийг илрүүлэн тэмдэглэл хөтлөн шийдвэрлэж ажилласан байна.<br>Багахангай тохижилт ОНӨААТҮГ нь орон сууцны айл өрхүүдийн хог хаягдлыг татан авах 7 бункер хогийн сав, хог хаягдал ангилан ялгах зориулалт бүхий 2 хогийн бункерийг угааж цэвэрлэн эвдрэл гэмтлийг засварлан өнгө үзэмжийг сэргээж будав.<br>Нийтийн эзэмшлийн талбай болон орон сууцны байрны гадна 40 ширхэг хогийн сав байрлуулан 7 хоног бүр чийгтэй цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг хийж хэвшээд байна.<br>ТХҮҮХ, хороодын ажлын алба, МХТ хамтран 2021.06.02-04-ний өдрүүдэд Төрийн байгууллага-30, Төмөр замын -10, Банк, санхүү-4, СӨХ-2, худалдааны-13, Барилгын материалын-2, Ахуй үйлчилгээний 10, нийт-71 ААНБ-д хог хаягдлын саваа угааж, өнгө үзэмжийг сайжруулах үүрэг чиглэлийг өгч ажиллав.<br>Тайлангийн хугацаанд ариутгал, халдваргүйтгэлийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Багахангай тохижилт ОНӨААТҮГ хамтран ковид-19 цар тахалтай холбоотой дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайд ариутгал халдваргүйжүүлэлт 4, Багахангай тохижилт ОНӨААТҮГ 24, нийт 28 удаа хийв.<br>Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 1.600.000 төгрөг гарган хороо тус бүрд нэг өрхийг сонгож стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгов. | | |
| 3.11 | Нутаг дэвсгэрийн хэмжээнд Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн Хамтын гэрээг бүртгэх, хамтын хэлэлцээрийг байгуулах, бүртгүүлэх ажлыг зохион байгуулж, ажилтан албан хаагчдын цалин хөлснөөс хуульд зааснаас бусад хураамж, шимтгэлийг шууд суутган | Нийслэлийн Аудитын газар, бусад санхүүгийн шалгалтаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийн дагуу хуульд зааснаас бусад хураамж, шимтгэлийг албан хаагчдын цалин хөлснөөс шууд суутган тооцохыг бүрэн зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлж хэвшүүлээд байгаа бөгөөд дүүргийн аж ахуйн нэгж, байгууллагуудын "төрийн сан"-аар дамжин хийгдэх цалингийн | 100 | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | тооцохыг таслан зогсоох арга хэмжээ авна. | гүйлгээнд хяналт тавин ажиллаж байна. Тайлангийн хугацаанд 4 хамтын гэрээ, бүртгэж, дугаар олгов. | | |
| 3.12 | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ өгсөн ажлын хэсгээс хүргүүлсэн зөвлөмж, дүгнэлтэд заагдсан ажлыг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж хагас, бүтэн жилээр тайлангийн хамт, үр дүнг нь үнэлэн нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлж ажиллана. | Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас тус ЗДТГ-ын 2020 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг цахимаар зохион байгуулсан бөгөөд одоогоор холбогдох ажлын хэсгээс зөвлөмж, дүгнэлт ирүүлээгүй байна. | - | - |
| 3.13 | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга болон төсвийн шууд захирагч нарын Төсвийн тухай хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийн хэрэгжилтэд хяналт тавина. | Нийслэлийн Засаг даргаас баталсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу төрийн сангийн нэгдсэн сангаар дамжин сар бүрийн 10-ны өдрийн дотор санхүүгийн дэмжлэгийн санхүүжилт хийгдсэн байна.<br>Төрийн сангийн нэгдсэн дансанд санхүүжилт хийгдэх бүрт орон нутгийн төсвөөс санхүүжих байгууллагуудын дансанд шилжүүлэн зарцуулалтын эрхийг нээж, гүйлгээ хийх боломжоор хангаж ажиллав.<br>2021 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн 10 байгууллагын 4,676.4 сая төгрөг, дүүргийн хөрөнгө оруулалтад нийт 162.1 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарийн дагуу бүрэн олгоод байна. | 100 | 100% |
| 3.14 | Орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхээр шилжүүлсэн зарим чиг үүрэг бүхий хөтөлбөр арга, хэмжээний үр дүнг нийслэлийн Засаг даргын өмнө хүлээнэ. | Дүүргийн хэмжээнд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжиж байгаа 3 байгууллага байна. Үүнд:<br>□ Хангай цогцолбор сургууль<br>□ 44-р цэцэрлэг<br>□ 207-р цэцэрлэг<br>Тус байгууллагуудыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулалтын чанар үр дүнтэй удирдлагаар байнга хангаж, төсвийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд хяналт тавих, хөтөлбөр үйлчилгээний стандарт тоо хэмжээ, чанар, хүртээмжийг сайжруулахад анхаарч ажилласнаар нийгмийн хөгжлийн хүрээнд хэрэгжүүлж буй хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд дэвшүүлсэн зорилтын хүрэх түвшнээс дээгүүр үзүүлэлттэй байна. | 100 | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3.15 | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгавар, 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус хэрэгжүүлж ажиллана. | Хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2021 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгон журмын 6.2, 6.3-т заасан аргачлалыг баримтлан хяналт үнэлгээ хийж, 95.2%-тай хэрэгжлээ. | 100 | 70% |
| ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ | | | | 97.6% |
| **Дөрөв. Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг хийх, зардлын зориулалт** | | | | |
| 4.1 | Төлөөлөн хэрэгжүүлэгч нь өөрийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бүтэн жилээр тооцно. | Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих 3 байгууллагын 2021 оны төсөв нь Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 сарын 14-ний өдрийн А/09 дүгээр тогтоолоор 1,521.4 сая төгрөгөөр батлагдсаны дагуу төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 | 100% |
| 4.2 | Хөтөлбөрийн санхүүжилтийг энэхүү гэрээний хавсралтад тусгагдсан хөтөлбөрийн төсөв, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн болон Нийслэлийн Засаг даргын баталсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулан гүйцэтгэнэ. | 2021 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийн Засаг даргаас баталсан тусгай шилжүүлгийн 3 байгууллагын нийт 1,552.0 сая төгрөгийн санхүүжилтийг батлагдсан сар, улирлын хуваарийн дагуу хөтөлбөр, зориулалтаар нь төрийн сангийн нэгдсэн данс болох ерөнхий боловсролын сургуулийн санхүүжилтийн 100200815100 данснаас “Хангай” цогцолбор сургуулийн 100200815102, Сургуулийн өмнөх боловсролын санхүүжилтийн 100200815200 данснаас 44 дүгээр цэцэрлэгийн 100200815202, 207 дугаар цэцэрлэгийн 100200815203 тоот дансуудаар тус тус олгож байна. | 100 | 100% |
| 4.3 | Нийслэлийн төрийн сан нь тусгай зориулалтын шилжүүлгийг сар бүрийн санхүүжилт орсноос хойш ажлын 2 /хоёр/ өдөрт багтаан дүүргийн төрийн сангийн зохих дансанд шилжүүлнэ. | Дүүргийн төрийн сан нь журмын дагуу тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагуудын дансанд тухай бүр шилжүүлэн зарцуулалтын эрх нээгдэж, төлбөр тооцооны гүйлгээ хийх боломжоор ханган ажиллаж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар Тусгай шилжүүлгийн 3 байгууллагуудад 1,552.0 сая төгрөгийн санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн олгоод байна. | 100 | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4.4 | Дүүргийн төрийн сан нь Засгийн газрын зарим чиг үүргийг хэрэгжүүлэгч орон нутгийн байгууллага тус бүрийн санхүүжилтийг төсвийн дансанд санхүүжилт орсноос хойш ажлын 1 /нэг/ өдөрт багтаан олгоно. | Нийслэлийн Төрийн сангаас дүүргийн Төрийн сангийн нэгдсэн дансанд сар бүрийн санхүүжилт орж ирсэн тухай бүрт санхүүжилтийн журамд заасан хугацаанд нь багтаан шилжүүлдэг бөгөөд нийслэлээс олгосон санхүүжилтийг зохих байгууллагад бүрэн шилжүүлсэн байна. | 100 | 100% |
| ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ | | | | 100% |
| **Тав. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх** | | | | |
| 5.1 | “Хотын хөгжлийн индекс”-ийн шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулан ажиллана. | Хотын хөгжлийн индексийн үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэв. Хороод болон холбогдох байгууллагуудтай хамтран анхан шатны мэдээллийг цуглуулж ЭАБ-ын маягтуудыг программд тулгалт хийж хянав. Дүүргийн индексийн нэгтгэл буюу датаг 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдөр НЗДТГ-т хүргүүлэв.<br>Дүүргийн хэмжээнд 2019 он болоод 2020 оны датад тулгуурлан харьцуулалт хийхэд:<br>- Ногоон байгууламжийн хэмжээ<br>- Ариун цэврийн шаардлага хангасан байгууламжтай өрх<br>- Цахилгаан эрчим хүчээр хангагдсан өрх<br>- Теле хяналтын камерын тоо зэрэг үзүүлэлтүүд сайжирсан байна.<br>Дүүрэгт “Жорлонгоо өөрчилье” аяныг зохион байгуулж Засаг даргын нөөц хөрөнгөөс тодорхой хэмжээний хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаа нь ариун цэврийн шаардлага хангасан байгууламжтай өрхийн тоо нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Мөн Нийслэл, дүүрэг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллуудын цахилгаан эрчим хүчний шугам сүлжээг сайжруулах, хяналтын камерын тоог нэмэгдүүлж ажилласан байна. | 90 | 70% |
| 5.2 | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны “Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр, стратеги төлөвлөгөө батлах тухай” 23/01 дугаар тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана. | Дүүргийн Авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг боловсруулан дүүргийн Засаг даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.<br>Тус хөтөлбөрийн 22 заалтыг хяналтад авч, 100%-ийн хэрэгжилттэй 19, 70% хэрэгжилттэй-3, үнэлэх боломжгүй 9, | 70 | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | өрөнхий үнэлгээ 96%-ийн хэрэгжилттэй байгаа бөгөөд дараах томоохон арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд: Дүүргийн хэмжээнд 2020 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын шинэчилсэн мэдүүлэг гаргах 26 албан тушаалтан мэдүүлгийг хүлээн авсан. Нийтийн албанд нэр дэвшсэн 4 иргэний ХАСУМ мэдүүлгийг АТГ хянуулахаар цахим болон цаасаар хүргүүлэв. Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, нийслэлийн 2021 оны хөтөлбөрийн 3 бүлэг 41 заалтыг хяналтанд авч, төлөвлөгөөний биелэлт 88.4%-тай хэрэгжлээ. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар байгууллага, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хүний нөөцийн бодлогод холбогдох заалтыг тусган хэрэгжүүлж байгаа бөгөөд дүүргийн вэб сайтын мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулж, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. АТГ-аас ирсэн 28 төрлийн 120 гаруй гарын авлагыг тарааж, 7 кино контент, 11 зурагт хуудсыг дүүргийн вэб сайт болон хэвлэл мэдээллийн групт байршуулсан. АТГ-аас ирсэн асуулгын дагуу 64 иргэнээс санал асуулга авч, 2021.09.11-ний өдөр АТГ-т хүргүүлэв.<br>НЗДТГ-тай хамтран Авлигын эсрэг хууль тогтоомжийн сургалтыг цахимаар 3 удаа зохион байгуулж, 11 удирдах албан тушаалтан, 21 албан хаагч, 4 ЭБАТ тус тус хамрагдсан байна. Иргэд, олон нийтийг мэдээ мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 7 төрлийн 50 гарын авлага, “Тат, түлх наалт 100ш хороодоор дамжуулан ААНБ-дад хүргүүлэв. | | |
| 5.3 | Нийслэлийн Засаг даргаас Багахангай дүүргийн Засаг даргад эрх шилжүүлэн хэрэгжүүлж буй 400,000.0 /дөрвөн зуун сая/ төгрөгийн өртөг бүхий 3 хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг нийслэлийн Засаг даргын өмнө хариуцна. | Нийслэлийн засаг даргын 2021 оны А/35 захирамжаар 400.0 сая төгрөгийн 3 ажлын эрх шилжин ирсэн. Үүнд<br>□ 1-р хороо 5, 6 байрны өмнөх авто замын шинэчлэлтийн ажлыг /асфальтан зам/ 100 хувь ашиглалтад хүлээн авсан.<br>□ Багахангай дүүргийн 2 дугаар хорооны орон сууцны 3, 4, 8 16 дугаар гадна фасад хийх ажлын гүйцэтгэгч Талст-Өндөрлөг ХХК үнийн өсөлттэй холбоотойгоор 3 байрны гүйцэтгэл 100 хувь биелүүлэн улсын комисст хүлээлгэн өгсөн.<br>□ Үнэгтэй болон Замчин гэр хорооллын гэрэлтүүлгийг шинэчлэн засварлах ажлыг Өндрийн-Уудам ХХК гүйцэтгэн 2021 оны 10 сарын 21-ний өдөр ашиглалтад 100 хувь хүлээлгэн | 100 | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | өгсөн. | | |
| 5.4 | Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас дүүрэгт 172,040.5 /нэг зуун далан хоёр сая дөчин мянга төвөн зуун/ төгрөгийн төсөл арга хэмжээг Орон нутгийн хөгжлийн сангийн журмын дагуу зохион байгуулж хэрэгжүүлнэ. | Дүүрэгт 2021 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 172.0 сая төгрөгийн 6 ажил хийгдэхээр болсон боловч 2021 оны дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын "Дүүргийн 2021 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" А/03 дугаар тогтоолоор 2021 оны төсөвт тодотгол хийгдэж 190,1 сая төгрөг буюу 8 ажил хийгдэхээр батлагдсан байна. Төсөл хөтөлбөр арга хэмжээний саналыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний батлагдсан хуваарийн дагуу 96,5%-ийн гүйцэтгэлтэй зохион байгуулсан. | 90 | 100% |
| 5.5 | Нийслэлийн төсөвт батлагдсан дүүргийн төрийн сангаар дамжин санхүүжиж буй нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавин, олгож, гүйцэтгэл үр дүнг нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнө хариуцна. | Нийслэлийн төсөвт батлагдсан дүүргийн төрийн сангаар дамжин санхүүжиж буй нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавин, жилийн эцсийн байдлаар нийт 32.8 сая төгрөг санхүүжилт хийгдсэнээс Олон нийтийн оролцооны түшиглэсэн үйлчилгээнд 32.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. | 100 | 100% |
| 5.6 | Нийслэлийн төсвөөс 2021 оны төсвийн жилд Багахангай дүүрэгт 4,238,707.5 /дөрвөн тэрбум хоёр зуун гучин найман сая долоон зуун долоон мянга төвөн зуун/ төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгоно. | Нийслэлийн төсөвт батлагдсан дүүргийн төрийн сангаар дамжин санхүүжиж буй нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавин, жилийн эцсийн байдлаар нийт 32.8 сая төгрөг санхүүжилт хийгдсэнээс Олон нийтийн оролцооны түшиглэсэн үйлчилгээнд 32.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.<br>Дүүргийн орон нутгийн төсөвт Нийслэлийн төсвөөс 2021 онд 4,238.7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгогдохоор батлагдсан бөгөөд тайлант жилд санхүүгийн дэмжлэг 100 хувь бүрэн хийгдсэн | 100 | 100% |
| 5.7 | Хотын ерөнхий менежерийн шуурхай зөвлөгөөнд хуваарийн дагуу оролцож, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн, үр дүнг хугацаанд нь тайлагнаж ажиллана. | Улаанбаатар хотын ерөнхий менежерийн шуурхай зөвлөгөөн 2021 оны байдлаар 24 удаа хуралдсан байна. Дүүрэгт хамаарах 5 бүлгийн 135 үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн бөгөөд 100%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна. | 100 | 100% |
| ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ | | | | 95.7% % |
| **Зургаа: Гэрээний хэрэгжилтийг дүгнэх тоон болон чанарын үзүүлэлт** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6.1 | Энэхүү гэрээний хавсралтаар батлагдсан шалгуурыг хангасан эсэхийг үнэлэхдээ Төсвийн тухай хууль болон тухайн салбарт мөрдлөг болгож буй хууль, дүрэм, журам , заавар стандарт, нормыг үндэслэл болгоно. | Төсвийн байгууллагын үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, Төрийн сангийн үйл ажиллагааны журам, холбогдох бусад хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар өдөр тутам заавар зөвлөгөө, зөвлөмж, чиглэл өгч хяналт тавин ажиллаж байна. | 100 | 100% |
| 6.2 | Гэрээний хавсралтын дагуу тухайн онд хэрэгжүүлэх, дүүрэгт шилжүүлж буй чиг үүргийг хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах урсгал болон бусад зардлын тоон дүн тус бүрээр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон үзүүлэлтийг дэлгэрэнгүй жагсаалтаар тус тус батална. | 2021 онд дүүрэгт хэрэгжүүлэх 10 хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах урсгал болоод бусад зардлын хүрэх үр дүнг чанарын болон тоон үзүүлэлтээр дэлгэрэнгүй боловсруулан гарган, ДИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/09 тоот тогтоолоор батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 | 100% |
| ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ | | | | 100% |
| **Долоо. Гэрээний хэрэгжилтийг тайлагнах, гэрээг дүгнэх** | | | | |
| 7.1 | Гэрээний хагас жилийн биелэлтийг 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор, бүтэн жилийн биелэлтийг 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлнэ. | Нийслэлийн Засаг дарга болон Багахангай дүүргийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний эхний хагас жилийн биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэст байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийн хамт 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдөр хүргүүлэв.<br>Жилийн эцсийн тайлан мэдээг холбогдох хэлтсээс авч нэгтгэн, үнэлгээ хийлгэн нийслэлийн Засаг даргын тамгын газрын хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэст хугацаанд нь хүргүүллээ. | 100 | 100% |
| 7.2 | Санхүүгийн улирлын тайланг дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор батлагдсан заавар, журмын дагуу гаргаж, хөтөлбөрийн үр дүнгийн тайлангийн хамт тухайн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ. | 2020 оны жилийн эцсийн Орон нутгийн төсвийн нийт 14 байгууллага, хөрөнгө оруулалтын 2 сан, ОНӨААТГ-ын 2, ахмадын байгууллагын нийт 19 санхүүгийн тайланг хүлээн авч хянан нэгтгэлд хамруулав. Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланг хууль, журам, стандартын дагуу гарган Нийслэл дэх төрийн аудитаар шалгуулж, зөрчилгүй санал дүгнэлт авч, НСТСХ-т хуулийн хугацаанд хүргэж ажилласан. ТЕЗ-ийн 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг онлайнаар хүлээн авч цаасан тайлантай тулган баталгаажуулж нэгтгэлийг НСТСХ-ийн | 90 | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | нэгтгэлд хамруулсан. Мөн орон нутгийн төсвийн байгууллагуудын 2021 оны 1, 3 дугаар улирлын санхүүгийн тайланг цаасаар хүлээн авч хянан баталгаажуулж ажиллав. | | |
| ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ | | | | 100% |
| **Үнэлгээний ерөнхий хувь** | | | | **98%** |

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.САНЖИЙЖАМЦ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ЭРХ ЗҮЙ, ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ,
ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН С.ЦЭНД-АЮУШ

НЭГТГЭСЭН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Х.ЦЭЦЭГСҮРЭН